



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 12 сарын 02 өдөр

Дугаар А/404

Улаанбаатар хот

“Маскаа зүүе” аян зарлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1, 11.2.4, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.5 дахь заалт, Монгол Улсын Шадар сайдын 2023 оны “Журам шинэчлэн батлах тухай” 28 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Томуу, томуу төст өвчний өвчлөл нэмэгдэж байгаатай холбогдуулан иргэдийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, амны хаалт хэрэглэж хэвшүүлэх, өвчлөлийг бууруулах зорилгоор “Маскаа зүүе” аяныг дүүргийн хэмжээнд 3 сарын хугацаатай зохион байгуулсугай.

2.Аяны хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллага, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн байгууллага, 1-24 дүгээр хороод, аж ахуйн нэгж байгууллага, үйлчилгээний төвүүдээр үйлчлүүлж буй иргэдэд амны хаалт хэрэглэж хэвшүүлэхийг уриалсугай.

3.Дээрх аяныг хэрэгжүүлж, үр дүнг танилцуулж ажиллахыг нийт байгууллагуудын удирдлагуудад, хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, ач холбогдлыг олон нийтэд сурталчлан түгээж ажиллахыг дүүргийн Засаг даргын Тамгын газар (Ж.Тамир)-т тус тус үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Бямбагэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.МАНДУУЛ